

## АГУУЛГА

Говь-Алтай аймгийн товч танилцуулга.....	2
Аймгийн нийгэм, эдийн засгийн товч мэдээлэл, 2017 оны байдлаар.....	3
Өрхийн орон сууцны нөхцөл.....	5
• Цахилгаан	
• Халаалт, дулаан	
• Усан хангамж	
Сурч боловсрох нөхцөл.....	7
Эрүүл мэндийн нөхцөл.....	8
Аюулгүй байдал.....	9
Хүн амын нийгмийн үзүүлэлт.....	11

## ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Говь-алтай аймаг нь 141.4 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, баруун талаараа Ховд, хойгуураа Завхан, зүүнээрээ Баянхонгор аймагтай, өмнөд хэсгээрээ БНХАУ-тай хиллэн оршдог. Нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ улсад Өмнөговь аймгийн дараа 2-р байрт ордог. Засаг захиргааны нэгжийн хувьд 2017 оны байдлаар 18 сум, 87 багтай 16.5 мянган өрхөд 57.4 мянган хүн амьдарч байна. Алтай хот нь далайн түвшнөөс дээш 2164 м-т өргөгдсөн монгол улсын хамгийн өндөрлөгт байгаа аймгийн төв, улсын нийслэл Улаанбаатар хотоос 1037 км алслагдсан. Нийт хүн амын 30.7 хувь буюу 17.6 мянга нь аймгийн төв Алтай хотод, 23.0 хувь буюу 13.2 мянга нь сумын төвд 1.6 хувь буюу 0.9 мянга нь тосгонд, 44.8 хувь буюу 25.7 мянга нь хөдөө амьдарч байна.

Баруун бүсийн аймгууд дотроос хамгийн цөөн хүн амтайд тооцогддог. Хүн амын дундаж наслалт 69.43 байна. Нийт хүн амын 25.9 мянга нь тодорхой хөдөлмөр эрхэлж байгаагийн дээр ажилгүй бүртгэлтэй иргэдийн тоогоор баруун бүсийн аймгууд дотроо хамгийн бага нь байдаг. Сүүлийн жилүүдэд аж үйлдвэрлэл нэлээд эрчимтэй хөгжсөний дотор эрчим хүч, уул уурхайн салбарт томоохон ахиц гарч, нүүрс, төмрийн хүдрийн олборлолт нэмэгдэж экспортын бүтээгдэхүүний дийлэнх хэсгийг эзэлж байна. Эрчим хүчний салбарт нийт 11 сум Тайширийн УЦС-аас 2.7 мВт эх үүсвэрээр, 5 сум Баруун бүсийн эрчим хүчний системээс Алтай, Бугат сумууд болон Баянтоорой тосгон нарны цахилгаан станц, дизель мотор хосолсон байдлаар ажиллаж хэрэглэгчдийг цахилгаанаар хангаж байна. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны байдлаар 13 тэрбум 449.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 226.9 сая төгрөг буюу 1.02 хувиар өслөө. Үүнд олборлох аж үйлдвэрийн салбарт 1.07 хувиар, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл 605.6 сая төгрөг буюу 1.05 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

## АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ, 2017 ОНЫ БАЙДЛААР

Хүн ам: Оны эцэст 16.5 мянган өрхөд 57.4 мянган хүн амьдарч байгаагийн 49.8 хувь буюу 28.6 мянга нь эрэгтэйчүүд, 50.2 хувь буюу 28.8 мянга нь эмэгтэйчүүд байна. Аймгийн дүнгээр бүтэн өнчин 51, хагас өнчин 1.0 мянган хүүхэд, арван найм хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлгүй хүн 1.0 мянга, ганц бие өндөр настан өрх 1.3 мянга, өрх толгойлсон 3.3 мянга, хөгжлийн бэрхшээлтэй 2.2 мянган хүн тус тус байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 24.4 хувь хөдөлгөөний согогтой, 10.1 хувь нь сонсгол, 4.1 хувь нь хэл ярианы согогтой, 5.5 хувь нь хавсарсан согогтой, 11.8 хувь нь эрхтний өөрчлөлттэй, 27.5 хувь нь бусад, 16.6 хувь нь сэтгэцийн эмгэгтэй хүмүүс байна.

Боловсрол: Ерөнхий боловсролын 28 сургууль, 29 цэцэрлэгт өсвөр үеийг сурган хүмүүжүүлж байна. ЕБСургуулиудад 11.4 мянган сурагч суралцаж, цэцэрлэгт 4.6 мянган хүүхэд хүмүүжүүлж байна. Энэ хичээлийн жилд 1-р ангид 1160 хүүхэд элсэн суралцаж байна.

Эрүүл мэнд: Аймгийн хэмжээнд 2017 оны эцэст 1216 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 1221 болж өнгөрсөн оны мөн үеийнхээс амаржсан эх 40 буюу 3.4 хувиар, хүүхэд 45-аар буюу 3.8 хувиар тус тус өссөн байна. Нялхасын эндэгдэл 20 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1 буюу 5.3 хувиар өсч, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 4 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 1 тохиолдлоор буурсан байна. 1000 амьд төрөлтөд ноогдох нялхсын эндэгдэл 16.4 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.2 пунктээр өссөн, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 19,7 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.7 пунктээр өссөн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчид 2017 оны эцэст 785 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 179 буюу 18.6 хувиар буурчээ. Халдварт өвчлөл буурахад улаан бурханаар өвчлөгчид өнгөрсөн өнгөрсөн оны мөн үеийнхээс 636 буюу 100 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Мал аж ахуй: Говь-алтай аймаг 2017 оны жилийн эцсийн мал тооллогоор 3801.7 мянган толгой мал тоологдсоны дотор адуу 123.7 мянган толгой, үхэр 85.4 мянган

толгой, тэмээ 41.9 мянган толгой, хонь 1196.6 мянган толгой, ямаа 2356.0 мянган толгой мал тус тус тоологджээ.

Барилга: Барилга угсралт , их засварын 9 тэрбум 861.8 сая төгрөгийн ажил хийж, үүнээс 9 тэрбум 233.3 сая төгрөгийн шинэ барилга өргөтгөл шинэчлэлт , замын засварын ажлыг гүйцэтгэсэн байна.Энэ онд 92 айлын орон сууц шинээр баригджээ.

### Өрхийн орон сууцны нөхцөл

Аймгийн нийт өрх 16494 болж өнгөрсөн оноос 1.5 хувь буюу 240 өрхөөр нэмэгдсэн байна. Нийт өрхийн 5128 өрх аймгийн төвд, 3784 өрх сумын төвд, 7305 өрх хөдөөд, 277 өрх тосгонд суурьшсан байна.


Сүүлийн жилүүдэд орон сууцны барилгууд нэмэгдэж 2017 онд гэхэд л 92 айлын орон сууц баригдсан.

#### Үүнээс

Бие даасан, тохилог сууц	Бусад сууц	Гэр	нийтийн байр	Орон сууцны байшин	Сууцны тусдаа байшин
79	84	13,539	220	1,184	1,388

Нийт өрхийн 83 хувь нь гэр хороололд, 7 хувь нь сууцны тусдаа байшинд, 7 хувь нь орон сууцны байшинд, 1 хувь нь нийтийн байранд 1 хувь нь бусад сууцанд, 1 хувь нь бие даасан сууцанд тус тусамьдарч байна.

#### Сууцны төрлөөр



Ахуйн нөхцөл

Цахилгааны эх үүсвэр	16716
Төвлөрсөн систем	7572
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	7110
Бага оврийн цахилгаан үүсгүүр	1363
Дизель станц	392
Цахилгааны эх үүсвэргүй	279

## Усан хангамж

Төвлөрсөн систем	1330
Бие даасан систем	129
Цооног	7623
Задгай	7634

## Халаалтын эх үүсвэр

Төвлөрсөн систем	1510
Нам даралтын зуух	276
Цахилгаан халаагуур	37
Ердийн галлагаа	14893

Суралцах нөхцөл

Ерөнхий боловсролын 28 сургууль, 29 цэцэрлэгт өсвөр үеийг сурган хүмүүжүүлж байна. ЕБСургуулиудад 11.4 мянган сурагч суралцаж, цэцэрлэгт 4.6 мянган хүүхэд хүмүүжүүлж байна. Энэ хичээлийн жилд 1-р ангид 1160 хүүхэд элсэн суралцаж байна. Ерөнхий боловсролын багш нар 697 байгаа бол өдрөөр суралцагчид 11358 байна.


Сумын нэр	Ерөнхий боловсролын сургууль			Цэцэрлэг		
	ЕБС-н тоо	1-р ангид элсэгчид	ЕБС-д өдрөөр суралцагчид	Цэцэрлэгийн тоо	Хүүхдийн тоо	Үндсэн багшийн тоо
Бүгд	28	1160	11358	29	4572	131
Есөнбулаг сум	6	503	4964	10	1889	56
Алтай сум	1	26	427	1	176	5
Баян-Уул сум	1	42	569	1	188	5
Бигэр сум	1	41	412	1	170	4
Бугат сум	2	44	352	1	160	5
Дарив сум	1	36	349	1	142	4
Дэлгэр сум	2	42	567	2	215	8
Жаргалан сум	1	17	151	1	87	3
Тайшир сум	1	8	90	1	70	2
Тонхил сум	2	45	412	1	193	5
Төгрөг сум	1	40	358	1	140	4
Халиун сум	2	20	191	1	127	3
Хөхморьт сум	1	41	345	1	152	5
Цогт сум	2	86	703	2	305	8
Цээл сум	1	45	396	1	119	3
Чандмань сум	1	44	417	1	160	3
Шарга сум	1	30	229	1	116	3
Эрдэнэ сум	1	50	426	1	163	5

### Эрүүл мэндийн нөхцөл

Аймгийн хэмжээнд 2017 оны эцэст 1216 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 1221 болж өнгөрсөн оны мөн үеийнхээс амаржсан эх 40 буюу 3.4 хувиар, хүүхэд 45-аар буюу 3.8 хувиар тус тус өссөн байна. Нялхасын эндэгдэл 20 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1 буюу 5.3 хувиар өсч, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 4 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 1 тохиолдлоор буурсан байна. 1000 амьд төрөлтөд ноогдох нялхсын эндэгдэл 16.4 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.2 пунктээр өссөн, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 19,7 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.7 пунктээр өссөн байна.



Халдварт өвчнөөр өвчлөгчид 2017 оны эцэст 785 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 179 буюу 18.6 хувиар буурчээ. Халдварт өвчлөл буурахад улаан бурханаар өвчлөгчид өнгөрсөн өнгөрсөн оны мөн үеийнхээс 636 буюу 100 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.



Аюулгүй байдал

Гэмт хэрэг: Байгууллага, иргэдийн 735.2 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулж, 200 гэмт хэрэг гарч, эдгээр хэргүүдээс танхай, хулгайн гэмт хэрэг, бусдын бие махбодид гэмтэл учруулсан гэмт хэргүүд 77.5 хувийг, нийт хэргийн 61.5 хувь нь Есөнбулаг сумд гарсан хэрэг эзэлж байна. Баривчлагдсан хүний тоо 140, өмнөх оны мөн үеэс 122 хүн буюу 6 дахин, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүний тоо 185, өмнөх онтой харьцуулахад 9 хүн буюу 4.9 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн төрөл	2016	2017	Харьцуулалт 2017/2016
Санаатай хүн амь	1	0	0
Болгоомжгүй хүн амь	0	0	0
Хүчиндэх	3	4	113.3
Дээрэмдэх	1	0	0
Танхай	8	7	87.5
ББМБГ учруулах гэмт хэрэг	71	73	102.8
Хулгайн гэмт хэрэг	55	66	120
Тээврийн хэрэгсэл	3	11	3 ДАХИН
Орон байрны хулгай	43	49	114
Малын хулгай	9	6	66.7
Бусад хулгай	0	0	0
Байгаль ХЖЭСрэг гэмт хэрэг	1	5	2 ДАХИН
Тээврийн ХХАБАЖЭ гэмт хэрэг	22	16	72.5
Залилах	3	8	2 ДАХИН
<b>БУСАД ХЭРЭГ</b>	<b>18</b>	<b>21</b>	<b>116.7</b>


Гэмт хэрэгт холбогдогч	2016	2017	Харьцуулалт 2017/2016
Эмэгтэй	19	24	126.3
Хүүхэд	12	14	116.7
Ажил мэргэжилгүй	92	75	81.5
Илрүүлээгүй хэрэг	12	53	4дахин
Урьд шийтгүүлсэн хүн	19	15	78.9
Илрүүлэлтийн хувь	76.90%	62.40%	14.5 пункт
Баривчлагдсан хүн	18	140	7 дахин
Саатуулагдсан хүн	636	476	74.8
Хохирол нөхөн төлөлт	201.7	275.2	136.4

Хүн амын нийгмийн үзүүлэлт


Оны эцэст 16.5 мянган өрхөд 57.4 мянган хүн амьдарч байгаагийн 49.8 хувь буюу 28.6 мянга нь эрэгтэйчүүд, 50.2 хувь буюу 28.8 мянга нь эмэгтэйчүүд байна. Аймгийн дүнгээр бүтэн өнчин 51, хагас өнчин 1.0 мянган хүүхэд, арван найм хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлгүй хүн 1.0 мянга, ганц бие өндөр настан өрх 1.3 мянга, өрх толгойлсон 3.3 мянга, хөгжлийн бэрхшээлтэй 2.2 мянган хүн тус тус байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 24.4 хувь хөдөлгөөний согогтой, 10.1 хувь нь сонсгол, 4.1 хувь нь хэл ярианы согогтой, 5.5 хувь нь хавсарсан согогтой, 11.8 хувь нь эрхтний өөрчлөлттэй, 27.5 хувь нь бусад, 16.6 хувь нь сэтгэцийн эмгэгтэй хүмүүс байна.

Сум	Бүтэн өнчин хүүхэд	Хагас өнчин хүүхэд	Өрх толгойлсон эрэгтэй	Өрх толгойлсон эмэгтэй	Ганц бие өндөр настан
Есөнбулаг сум	19	469	78	839	401
Алтай сум	1	30	25	86	33
Баян-Уул сум	5	39	38	64	52
Бигэр сум	1	25	35	94	38
Бугат сум	4	25	21	68	50
Дарив сум	0	16	30	91	39
Дэлгэр сум	2	34	21	145	69
Жаргалан сум	0	15	15	64	38
Тайшир сум	2	18	16	49	40
Тонхил сум	0	27	30	122	72
Төгрөг сум	1	25	21	97	41
Халиун сум	1	60	54	90	52
Хөхморьт сум	3	37	82	92	78
Цогт сум	1	38	65	182	77
Цээл сум	2	27	19	107	44
Чандмань сум	1	33	86	139	47
Шарга сум	3	21	48	112	55
Эрдэнэ сум	3	30	48	108	47
<b>Нийт</b>	<b>51</b>	<b>969</b>	<b>732</b>	<b>2539</b>	<b>1273</b>

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, жил бүрийн эцсийн байдлаар



Бүртгүүлсэн гэрлэлт, цуцлалт



## ДҮГНЭЛТ

Говь-Алтай аймаг нь Улаанбаатар хотоос 1037 км-ийн зайтай оршдог төвөөс алслагдсан аймгуудын нэг юм. Төвөөс хэт алслагдсан, дэд бүтэц муу зэргээс шалтгаалан шилжилт хөдөлгөөн их байсан боловч сүүлийн жилүүдэд шинээр барилга, байгууламж нэмэгдэж, цахилгаан, дулааны эх үүсвэрүүдээр хангагдан амьрах орчин нөхцөл жилээс жилд сайжирч байна. Өмнөх жилүүдтэй харьцуулахад шилжилт хөдөлгөөн багасч шилжин явсан хүний тоо буурсан байна. Мөн шинээр ашиглалтанд оруулж буй орон сууцны тоо өсчээ. Эрүүл, мэндийн салбарын тухайд хүн амд хүрч үйлчлэх, үйлчилгээгээ сайжруулах тал дээр нилээдгүй ажиллаж байгаагаас нялхасын эндэгдэл болон халдварт өвчлөлийн тоо зэрэг эрүүл мэндийн гол үзүүлэлтүүд буурч байна.

Аймгийн хэмжээнд 28 сургууль, 29 цэцэрлэг үйл ажиллагаа явуулдаг ба боловсролын үйлчилгээг чанартай явуулсаар байна. Баруун бүсийн бусад аймгуудтай харьцуулахад хүн ам цөөн хэдий ч сүүлийн жилүүдэд дэд бүтэц сайжирч байгаатай холбоотой шилжилт хөдөлгөөн багасч хүн ам, өрхийн тоо өссөөр байна.

Ашигласан материал, ном зүй:

1. Аймгийн 2017 оны жилийн эцсийн нийгэм, эдийн засгийн танилцуулага
2. Хүн ам, өрхийн мэдээллийн сан
3. Монгол улсын статистикийн эмхэтгэл-2017
4. [www.1212.mn](http://www.1212.mn) сайт
5. Говь-Алтай аймгийн статистикийн эмхэтгэл 1940-2013